

МОНГОЛЧУУДЫН АМЬДРАЛЫН ЧАНАРТ НӨЛӨӨЛЖ БУЙ ЗАРИМ ХҮЧИН ЗҮЙЛСИЙН ШИНЖИЛГЭЭ

М.Батбаатар
Социологийн ухааны доктор (Ph.D)

Амьдралын чанарын тухай авч үзэх нь

Социализмын дараах нээлттэй, зах зээлийн нийгэмд амьдарч буй хүмүүсийн орчин нөхцөл, ахуй амьдрал, харилцаа, хандлага, оршин ахуйн үнэлгээ болоод асуудал, хэрэгцээ, сэтгэл ханамж үлэмж өөрчлөгдлөө. Үүнтэй уялдан хүний амьдралын чанар хэрхэн өөрчлөгдөж байгааг, нийгмийн амьдралд гарч буй макро болон микро өөрчлөлтүүдтэй холбон судлах зайлшгүй шаардлагатай. Учир нь өнөөгийн ядуурал болоод хөгжил, эдийн засгийн өсөлт хийгээд бууралт, нийгмийн ахиц дэвшил болоод ухралт, хөгжлийн тулгамдсан асуудлууд болоод бодлогын шийдвэр бүхэн хүний амьдралын чанартай ямар нэгэн учгаар холбогдсон байдаг.

Орчин үед улс орнуудын хөгжлийн түвшинг хүний хөгжлийн индекс болон мянганы хөгжлийн зорилтын үр дүнгийн багц шалгуур үзүүлэлтээр тодорхойлж буй ч, эдгээр нь хүний амьдралыг бодитой, бүрэн гүйцэд илэрхийлээгүй, нийгэм, орчны сайн сайхан байдлын үзүүлэлтийг орхигдуулсан зэргээрээ шүүмжлэгддэг бол харин амьдралын чанарын үзэл баримтлалд эдгээрийг бүхэлд нь цогц хэлбэрээр, харилцан уялдаатай авч үзсэнээрээ онцлог бөгөөд дэвшилттэй юм. Хүний хөгжлийн үзүүлэлтэд одоогийн амьдралын нөхцөл ба тэрхүү нөхцөл байдлын талаарх хүний сэтгэл ханамж болоод үнэлгээ орхигдсон байдаг. Гэтэл угтаа хүн бол зөвхөн хөгжиж буй субъект бус, хөгжүүлэх ёстой объект ч бус, амьдралын олон талт хүчин зүйлсээс шалтгаалан хамаарч буй объект хийгээд үйлдэн амьдарч буй субъектийн аль алин нь мөн.

Иймд энэхүү өгүүлэлд өнөөгийн Монголчуудын амьдралын чанарт гарч буй өөрчлөлтийг бусад улс орны амьдралын чанарыг илэрхийлсэн үзүүлэлт, аргачлалтай харьцуулсан. Өөрчлөгдөн буй дэлхий ертөнц дэх Монголчуудын амьдралын чанарыг хэмжих, түүнд гарч буй өөрчлөлт, нөлөөлж буй хүчин зүйлсэд социологийн тайлбарлал хийх нь нийгмийн ахиц, хөгжил дэвшлийн судалгаанд ч, нийгмийн хөгжил дэвшлийн тайлбарт ч, хүний хөгжлийн үзэл баримтлалд ч арга зүйн хувиар чухал ач холбогдолтой. Дэлхий нийтээр эдүгээг хүртэлх амьдралынхаа сургамжид үндэслэн цаашид хүн төрөлхтөн хэрхэн амьдрах тухай шинэ үзэл баримтлал, шинэ зарчмууд бүхий амьдралын шинэ загварыг дэвшүүлэх оролдлого хийсээр байгаа өнөөгийн нөхцөлд Монгол хүний амьдралын чанарыг хэмжих шалгуур үзүүлэлтийг олон нийтийн үнэлгээнд тулгуурлан Монголчуудын амьдралын чанарт нөлөөлж буй хүчин зүйлсэд шинжилгээ хийсэн.

Тогтвортой хөгжлийн үндсэн тулгуур багана болох эдийн засаг, нийгэм, хүрээлэн буй орчин зэрэг гурван нийтлэг хэмжүүрийг уялдуулан тэнцвэржүүлэхэд даян дэлхийн XXI зууны хөтөлбөрийн зорилго чиглэх болсон эрин үед чухамдаа хүний сайн сайхан байдал, амьдралын чанарыг эдийн засаг, нийгэм, хүрээлэн буй орчны хүрээнд хангах явдал хойшлуулшгүй чухлаар тавигдаж байна. Учир хэмээвээс 1) хөгжингүй орнуудын хувьд ядуурлыг эдийн засгийн өсөлтөөр бууруулах оролдлого эдүгээ бүтэлгүй болсон төдийгүй эдийн засгийн үндсэн үзүүлэлт болох баялаг, нөөц, бараа үйлчилгээ зэргээс үл хамаарч хүний амьдралын чанар доройтох хандлага ажиглагдах болсон,

2) хүрээлэгч орчин тогтвортой хөгжлийн үндсэн тулгуур болохыг нийтээрээ хүлээн зөвшөөрч байгаа боловч экосистемийн тэнцвэрийн алдагдал улс орнуудад нүүрлэж, энэхүү нөхцөл уул уурхай олборлолт давамгайлж буй улс оронд улам бүр эмзэг болж байгаа, 3) нийгмийн хөгжилд ардчилал, зах зээлд шилжих үйл явц онцгой нөлөө үзүүлж, нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд хүмүүсийн оролцоо илт нэмэгдсэн ч, нөгөө талаас нийгмийн орчны хувьд гэмт хэрэг, түгшүүрт байдал илт өсөж, байгалийн орчны хувьд хүний амьдрах орон зай бохирдож, орчны тэнцвэр алдагдаж буй дүр зураг харагдаж байна. Дээрхээс үзэхэд амьдралын чанар хэмээх ойлголт бол түгээмэл шинжтэй тул эл үзэгдлийг судлах арга зүйн хандлагаа нэн тэргүүнд тодорхойлох шаардлагатай.

Хүснэгт 1. Амьдралын чанарыг судлах арга зүй

Хандлага	Тодорхойлолт
Концептуал загвар (Conceptual Model)	Амьдралын чанарын шинж чанар болон хэмжигдэхүүнийг тусгайлан авч үздэг (түгээмэл) загвар.
Концептуал хүрээ (Conceptual Framework)	Амьдралын чанарын хэмжигдэхүүн болон түүний элемент хоорондын харилцааны мөн чанарыг тодорхойлж, тайлбарладаг.
Онолын хүрээ (Theoretical Framework)	Амьдралын чанарын элементүүдийн бүтэц, харилцаа холбоог тодорхой онолын үүднээс тайлбарладаг(түгээмэл биш).

Эх сурвалж: Taillefer, Marie Christine, Dupuis, Gilles, Roberge, Marie-Anne and Lemay, Sylvie (2003) 'Quality of Life Models: Systematic Review of the Literature', *Social Indicators Research*, Vol. 64, No. 2, P. 299 (Worldbank, UNICEF, North Ireland, NSO, 2000)

Амьдралын чанарыг судлах онолын хүрээг авч үздэг арга зүйн хандлагын хувьд амьдралын чанарын бүтэц, бүрэлдэхүүнийг тодорхой онолын үүднээс тайлбарладаг боловч “амьдралын чанар” хэмээх ойлголтын агуулга, мөн чанарт багтах бүрэлдэхүүн элементүүд, тэдгээрийн харилцааны мөн чанарт түгээмэл тайлбарлал хийдэггүй. Амьдралын чанарыг судалдаг дараагийн хандлага болох концептуал хүрээний хувьд амьдралын чанарын хэмжигдэхүүнийг авч үзэж, түүнийг бүрдүүлэгч эд эсэд тайлбарлал хийдэг боловч, эдгээрийг нарийвчлан хэмжиж түгээмэл загвар гаргахад чиглэдэггүй болно. Амьдралын чанарыг судлах дээрх арга зүйн загвараас зохиогч эхний буюу концептуал загварыг өөрийн судалгааны арга зүй болгосон. Учир нь амьдралын чанар хэмээх ойлголт нийгмийн нарийн нийлмэл үзэгдэл болох хувьдаа объектив ба субъектив шинж чанаруудаар илрэх бөгөөд тэдгээр хэмжигдэхүүн бүр улс орон бүрт түгээмэл шинжтэй, арга зүйн хувьд харьцуулах боломжтой байхыг урьтал болголоо.

Монголчуудын амьдралын чанарт нөлөөлж буй зарим хүчин зүйлс

Статистик тоон мэдээ болон санал асуулгын үр дүнд тулгуурлан¹²⁵ Монголчуудын амьдралын чанарт нөлөөлж буй зарим хүчин зүйлсээр хийсэн шинжилгээг энд товч танилцуулъя. Статистик тоон мэдээнд тулгуурлан авч үзэхэд нийгэм эдийн засгийн суурь нөхцөлүүдэд зарим өөрчлөлт гарсаар байна.

Хүснэгт 2. Нийгэм эдийн засгийн суурь өөрчлөлтүүд

	Он	2010	2011	2012	2013	2014	Дундаж
1	Инфляци	13	12.6	12.3	12.5	13.7	12.8
2	Ажилгүйдлийн түвшин	9.9	10.1	10.3	9.3	9.4	9.8
3	Ядуурлын түвшин	38.7	33.7	27.4	---	---	33.3
4	Нас баралт	6.7	6.9	6.3	5.9	---	6.5
5	Дундаж наслалт	68.1	68.3	68.7	69.1	68.5	68.5
6	Хүний хөгжлийн индекс	0.763	---	---	---	---	0.763

Эх сурвалж: Статистикийн эмхтгэл. 2010-2014,
Хүний хөгжлийн илтгэлийн хураангуй. 2010-2014

Макро түвшний үзүүлэлтийг тусгасан хүснэгтээс үзвэл инфляци тогтвортой өсөх хандлагатай, ажилгүйдлийн түвшин харьцангуй буурч (0.5 пунктээр), ядуурлын түвшин бага зэрэг буурах зүй

125 Монголчуудын амьдралын чанарын үзүүлэлт, үнэлэлт, дүгнэлтийг санал асуулгын аргаар тодруулсан болно. Үүнд МУИС-ийн Социологи, Нийгмийн ажлын тэнхмээс эрхлэн 2009, 2012, 2014 онуудад явуулсан “Монголын нийгмийн харилцааны өөрчлөлт, хандлага” сэдэвт судалгааны дүн, мөн 2013 оны зохиогчийн бие даасан судалгааны дүнг ашигласан болно.


тогтол ажиглагдаж байна. Түүнчлэн нас баралтын түвшин бага зэрэг буурсан (0.8 пунктээр) бол дундаж наслалт өсөөд, буурчээ. Олон улсын практикт эдгээр үзүүлэлтүүд хүний амьдралын чанарт шууд болон урвуу, эерэг болон сөрөг харилцан адилгүй нөлөө үзүүлдэг болохыг хэдийнээ тогтоосон (M.Batbaatar, Methodological issues of quality of life study, 2012) байна.

Дээрх макро үзүүлэлтэд тулгуурлан улс орнуудын амьдралын чанарын индексийг тооцоолж үзэх нь олонтаа байдаг. Тухайлбал, Монгол Улсын 2005-2008 оны амьдралын чанарыг “Олон улсын амьдралын чанар” (*International living*) байгууллага барагцаалан тооцоолж дараах үр дүнг мэдээлжээ. Тухайлбал, Монголчууд амьдралын чанарын түвшингээр харьцуулсан 198 орноос 2006 онд 114-т, 2007 онд 108-д, 2008 онд 100-р байранд тус тус орж байсан аж. Уг мэдээллээс харахад Монголчуудын амьдралын чанар бусад улс оронтой харьцуулахад байр ахих эерэг хандлагатай байна. Мөн судалгаанд дурдсанаар эрх чөлөө, ардчилал гэсэн нийгэм, улс төрийн үзүүлэлт харьцангуй тогтвортой, өндөр үнэлгээтэй, нөгөө талаас шилжилтийн дараах улс орнуудтай харьцуулахад дунджаас дээгүүр үзүүлэлттэй байсан болно. Түүнчлэн манай улсын хувьд амьдралын өртөг, хүрээлэн буй орчин зэрэг үзүүлэлт харьцангуй өндөр үнэлгээтэй гарсан нь сонирхол татаж байна. Бодит байдалд амьдрах өртөг зардал сараар биш өдрөөр өсөж, азийн болон дэлхийн улс орнуудын дунд явуулсан харьцуулсан судалгаанаас хот орчмын агаарын бохирдлоор өндөр орнуудын тоонд ордгийг (2-3-р байрт, индекс тооцоолол хийдэг цахим хуудасны [www.numbeo.com] үр дүнгээр 96.71 буюу маш их гарсан) бид мэднэ. Соёл урлаг, чөлөөт цаг, эрсдэл болон аюулгүй байдал, эрүүл мэнд зэрэг үзүүлэлт дундаж үнэлгээтэй гарсан бол, эдийн засаг, дэд бүтэц зэрэг үзүүлэлт багавтар, цаг агаар хамгийн бага үнэлгээ авсан байна. Эрс тэс уур амьсгал, өвөл зуны температурын зөрөө их (-40⁰Сээс +40⁰С), 10 жил тутмын давтамжтай зуд турхан зэрэг байгалийн гамшигт үзэгдлүүд энэхүү үнэлгээнд сөргөөр нөлөөлсөн байхыг үгүйсгэхгүй. Дээрх мэдээлэлд тулгуурлан шилжилтийн эдийн засагтай улс орнуудын амьдралын чанартай харьцуулан үзвэл, Монгол Улс 26 орноос 55.6 гэсэн дундаж үнэлгээгээр 10-р байранд орсон нь дундаж түвшинд байгааг харуулах боловч эдгээр мэдээллийг ямар эх сурвалжаас авч ашигласан нь тодорхой бус аж. Тухайн аргачлалаар явуулсан хэд хэдэн судалгаанд Монголчуудын амьдралын чанарыг хэмжих оролдлого хийсэн [2005-2008] бөгөөд статистик мэдээллийн хувьд учир дутагдалтай байна. Тухайлбал, а) энэ чиглэлийн статистик болон бүртгэл судалгаа дутмаг, б) тухайн хэмжих үзүүлэлтийг харьцуулан нэгтгэхдээ хүний хөгжлийн нийтлэг индексийг гол шалгуур болгосон байна. Иймд амьдралын чанарын суурь үзүүлэлтийг гаргах зорилгоор МУИС, Залуучуудын болон олон улсын байгууллагын санхүүгийн дэмжлэгтэйгээр¹²⁶ суурь судалгаа хийж, үр дүнг тооцож үзэв. Судалгаанд амьдралын чанарыг хэмжихдээ нэг ижил шкал [маш сайн-5:4:3:2:1-маш муу] хэрэглэсэн нь харьцуулалт хийх, үр дүнг гаргаж авахад эерэг нөлөө үзүүлсэн.

Хүснэгт 3. Санал асуулгын үр дүн

	2009	2012	2013	2014
Санал асуулгад оролцогчдын тоо	n=1070	n=718	n=2100	n=2610
Амьдралын асуудал: байгаль орчин	3.33	3.28	2.88	3.31
Амьдралын асуудал: нийгмийн орчин	3.18	3.39	3.35	3.40
Амьдралын нөхцөл, хэрэгцээ хангалт	3.16	3.41	3.48	3.41
Амьдралын сэтгэл ханамж	3.26	3.40	3.69	3.76
Дундаж үзүүлэлт	3.23	3.37	3.35	3.48
10 хүртэлх коэффициентоор	6.46	6.74	6.7	6.96
100 хүртэлх хувиар илэрхийлвэл	64.62	67.39	67.01	69.60

126 Ёйгмийн ардчилал Монголын залуучуудын холбоо, Фридрих Эбертийн сан. 2013



Амьдралын чанарын үзүүлэлтийг 1-5 хүртэлх баллаар үнэлүүлсэн бөгөөд үнэлгээний дундаж үзүүлэлтэд тулгуурлан амьдралын чанарын өнөөгийн нөхцөл байдлыг гаргасан болно. Судалгаанд оролцогчид өөрсдийн амьдралын чанарыг дунджаас дээгүүр үнэлсэн бөгөөд харьцангуй өсөх хандлага ажиглагдаж байна.

Дээрх үнэлгээний дунджийг асуудал, хэрэгцээ, сэтгэл ханамж гэсэн үндсэн хэсгүүдээр авч тус бүрт нь тайлбарлал хийлээ. Хүн амын амьдрал ахуйд нийгэм-эдийн засаг, байгаль орчны ямар асуудлууд

тулгамдсан шинжтэй байна, ард иргэдийн амьдралын нөхцөл, хэрэгцээ хэрхэн хангагдаж байна гэдгээс хамааран тэдгээрийн амьдралын сэтгэл ханамж шууд тодорхойлогдоно.

Монголчуудын амьдралын чанарт нөлөөлж буй байгалийн орчны хүчин зүйлсийг үнэлэхэд дундаж үнэлгээ тогтвортой буурах хандлага ажиглагдаж байгаа (2009 онд 3.33 байсан бол 2014 онд 3.31 болжээ) юм. Харин амьдралын чанарт эерэгээр нөлөөлж буй нийгмийн орчны асуудал харьцангуй сайжирч байгааг иргэд тэмдэглэжээ. Энэ хугацаанд нийгмийн орчны асуудлын үнэлгээ 3.18-3.4 хүртэл хувиар өссөн байна. Амьдралын нөхцөл, хэрэгцээ хангалтын хувьд ч тогтвортой өсөх хандлага (дурдсан хугацаанд 3.16-3.41 болж өссөн) ажиглагдаж байна. Амьдралын сэтгэл ханамжийн үнэлгээ мөн хугацаанд 3.23-3.48 хүртэл өссөн байгааг хүснэгт 3-аас харж болох юм.



Дүрс 1. Амьдралын чанарын дундаж үзүүлэлт

Хүснэгт.3-д тусгасан хүн амын амьдралын чанарын дундаж үнэлгээний өөрчлөлтийг судалгаа хийгдсэн онуудаар харцуулан хандлагыг тодорхойлоход(excel / trend/ regression type / logarithmic) дараах онцлог ажиглагдаж байна. Тухайлбал, нийгмийн орчны асуудлын хувьд эерэг үнэлгээ буурч, сөрөг үнэлгээ өсөх төлөв ажиглагдсан. Хүн амын амьдралын чанарт байгалийн орчноос дутуугүй нөлөө үзүүлж буй томоохон бүрэлдэхүүн хүчин зүйл бол нийгмийн асуудал мөн. Эдгээрийг дундажлан хүн амын амьдралын чанарт хэрхэн нөлөөлж буйг харьцуулан харж болохын дээр хялбар дүрслэл бүхий тооцоолол (excel/trend/regression type/logarithmic) ашиглан цаашдын хандлагыг зураглаж болох юм.

Уг тооцооллоор нийгмийн орчны асуудлын хувьд эерэг үнэлгээ цаашид харьцангуй өсөх төлөв харагдаж байна.

Амьдралын чанарт нөлөөлж буй байгалийн болон нийгмийн орчны өөрчлөлтийг авч үзэхэд байрлалаа сольсон, дүрслэн өгүүлбэл “хайч” маягийн өөрчлөлт гарчээ. Өөрөөр хэлбэл уг хоёр үзүүлэлт суурь онтой харьцуулахад 2010 он хүртэл нийгмийн орчны асуудлын үнэлгээ жигд өсөж (харин байгалийн орчны асуудлын үнэлгээ жигд буурч), 2011 оны үед эдгээр асуудлууд байрлалаа сольсон байна. Энэхүү үзүүлэлтийн зэрэгцээ амьдралын түүхийн судалгааны¹²⁷ хүрээнд цуглуулсан тоон мэдээлэлд тулгуурлан шилжилтийн дараах Монголчуудын амьдралын чанарын гол үзүүлэлтийн өөрчлөлтийг тооцож үзэхэд хэд хэдэн онцлог ажиглагдаж байна.

127 Амьдралын түүхийн судалгааны үр дүнгээс. 2013. М.Батбаатар




Биологийн болон ахуйн хэрэгцээний хувьд хүнс тэжээл, орон байр, сууцны нөхцөл, дэмжлэг туслалцаа болон орлогын хүрэлцээ зэрэг хүчин зүйлсийг харьцуулж үзсэн. Амьдралын түүхийн сурвалжлагад орсон хүмүүсийн үнэлгээг дундажлан авч үзэхэд 1990-1994 оны хооронд хүмүүсийн хэрэгцээ хангагдах байдал ихээхэд доогуур байсныг (хүнс хоол, тэжээл, дэмжлэг туслалцаа тааруу буюу муу-2.0, орлогын хүрэлцээ-2.5, орон байр сууц-3.0 гм) харж болох бөгөөд эдгээр хэрэгцээ хангагдахгүй байдал нь нийгмийн хэрэгцээ болон оюуны бусад хэрэгцээний үнэлгээнд шууд сөрөг нөлөө үзүүлсэн байна. Хүнд юуны өмнө идэж уух, өмсөж зүүх физиологийн хэрэгцээ хангагдсаны дараагаар дурдан буй нийгмийн хэрэгцээ дэвшигддэг онцлогтой.

Нийгмийн хэрэгцээ, түүний хангагдах байдал: Амьдралын чанарыг тодорхойлох суурь бөгөөд үндсэн хүчин зүйл бол анги давхаргад эзлэх нийгмийн байр суурь, суралцах, хөгжих болон амарч зугаалах хэрэгцээ хийгээд тэдгээрийн хангагдаж буй байдал мөн.

Монголчуудын анги давхаргад эзлэх нийгмийн байр суурийн үнэлгээ дунджаар 2.9-3.35 гэсэн үнэлгээтэй байгаа нь 1-рт, хүмүүсийн үнэлгээнд зонхилж буй хандлага, 2-рт, ерөөс өнөөгийн нийгэм дэх анги давхаргын төлөвшилт, өөрчлөлт, онцлогтой холбоотой юм. Нийгмийн байр сууриа дунд хэмээн үнэлж буй энэхүү хандлага нь ахуйн хэрэгцээний хангамж сайжирсантай холбоотой биш, сурч боловсрох хэрэгцээ боломжийн түвшинд хангагдах (4.6-4.8) болсонтой ч шууд утгаараа холбоотой биш, харин дээр дурдсан бүхий л хүчин зүйлийг өөртөө агуулсан “тэдгээрийн учиг, гогцоо” болохыг судалгааны үр дүнгээс харж болно. Амьдралын нөхцөл болон хэрэгцээ хангалт чухам ямар байгаагаас хамааран амьдралын сэтгэл ханамжийн үнэлгээ тодорхойлогдож байдаг ажээ.

Оюуны хэрэгцээ хангалт ба сэтгэл ханамжийн өөрчлөлтийн хувьд: 1990-ээд оны эхний хагасыг суурь болгон тооцоход хүн амын оюуны хэрэгцээ хангалтад чанарын өөрчлөлт, ахиц дэвшлүүд гарч буйг судалгааны дүн нотолж байна. 1990 оны эхэн хагастай харьцуулахад 2010 оны байдлаар бүтээж туурвих, мөрөөдлөө биелүүлэх хэрэгцээ, түүний хангагдах байдлын үнэлгээний дундаж тасралтгүй өссөн зүй тогтол харагдаж байна. Амьдралын чанарын бусад үзүүлэлтээс хамааран хүний амьдралын сэтгэл ханамж өөрчлөгдөхөөс гадна хүний энэхүү үнэлэмж, хандлага амьдралын чанарыг үнэлэх үндсэн үзүүлэлт болдог. 1990-ээд оны эхэн үеийн амьдралын сэтгэл ханамж төдийлөн сайн биш (2.8) байсан бол 2010 оноос хойшхи байдлаар дунджаас дээгүүр үнэлэгдсэн байгаа нь амьдралын сэтгэл ханамж ерөнхийдөө дээшилж байгааг илэрхийлэх юм.



Дүгнэлт

Хүн амын амьдралын чанарыг дээшлүүлэх нь Мянганы хөгжлийн нэгдүгээр зорилт, төрөөс хүн амын талаар баримтлах бодлогын үндсэн бүрэлдэхүүн хэсэг бөгөөд Монгол Улсын хувьд тулгамдсан бөгөөд хойшлуулшгүй чухал асуудлын нэг байсаар байна, цаашид ч байх болно.

Монгол Улс нийгэм эдийн засгийн шилжилтийг “шаталсан бус”, харин “цочир эмчилгээний” стратеги баримтлан хийсэн нь нийгэмд сөрөг үр дагавар ихээр бий болгож, хүн амын дунд ажилгүйдэл, ядуурал бий болж, лавшран гүнзгийрэх нөхцөлийг бүрдүүлсэн юм. ОУВС-ийн Монголд тулган явуулсан мөнгөний хатуу бодлого нь зээлийн өндөр хүүг бий болгосноороо дотоодын хөрөнгө оруулалтыг ямарч боломжгүй болгож, Монголын үйлдвэрийг сүйрэлд оруулсан хэмээн судлаач Кийт Гриффины (Griffin, 2003) бичсэнтэй зохиогч олон талаар санал нийлж байгаа болно.

Учир гэвэл, гарааны тэгш бус нөхцөлд явагдсан, шударга бус өмч хувьчлал өнөөгийн нийгэм, эдийн засгийн олон тооны асуудал үүсэх(орлогын хомсдол, үнийн хөөрөгдөл, ядуурал, тэгш бус байдал, ажилгүйдэл, гэмт хэрэг г.м.) үндсэн эх сурвалж гол гогцоо байсан юм.

Судалгаанаас үзвэл, шилжилтийн эхэн үеийн Монголчуудын амьдралын чанарт төвлөрсөн төлөвлөгөөт тогтолцооноос зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжих шилжилтийн үеийн улс төр, эдийн засаг, нийгмийн өөрчлөлтүүд, байгаль цаг уурын гамшигт болон аюулт үзэгдлүүд, хүн амын дунд бий болсон ажилгүйдэл болон ядуурал зэрэг хүчин зүйлс онцгой нөлөө үзүүлсэн байна. Энэ үеийн Монголчууд өмчлөлийн талаарх ойлголт, төсөөлөл бага, хувьдаа эд мөнгө хураасан хүмүүсийг “сулдаг, шунахай” хэмээн үздэг байсан нийтийн өмчийн эрин үеэс эргэлт буцалтгүйгээр “салсан” боловч, мөнгө, эд юмсад хандах хандлага төлөвшин тогтоогүй, үнэтэй ба үнэ цэнэтэй зүйлсийн ялгааг мэдэхгүй байсан зэргээрээ тухайн үеийн Монголчуудын хэрэгцээ “юмтай байх” түвшинд эргэлдэж байсан юм.

Шилжилтийн дунд хугацаанд эдийн засгийн өсөлт тогтворгүй, зарим жилүүдэд эргээд буурсан бол, урт хугацаанд авч үзэхэд Монгол Улсын эдийн засгийн нөхцөлд өсөлтийн ерөнхий чиг хандлага ажиглагдаж байна.

Шилжилтийн дараах амьдралын чанарын нөхцөл байдлыг бүхэлд нь дүгнэж үзэхэд Монголчуудын амьдралд тулгамдаж буй нийгэм, байгалийн хүчин зүйлс, эдийн засгийн асуудлаас үндсэндээ давамгайлж, амьдралын нөхцөл, хэрэгцээ хангагдах байдалд сөргөөр нөлөөлж, улмаар хувь хүний амьдралын сэтгэл ханамжийг бууруулахад зонхилох нөлөө үзүүлсэн байна. Чухам энэ үеэс Монголчуудын хэрэгцээнд зарчмын гэмээр өөрчлөлт гарч “юмтай байх” эдийн хэрэгцээний түвшнээс, “харилцаа холбоотой байх” зарчмын өөр гэмээр нийгмийн хэрэгцээний түвшин рүү аажмаар гулсалт хийж, чанарын хувьд ахиц дэвшил явагдаж эхэлжээ.

Дэлхийн улс орнууд хөгжлийн түвшингээ хүний хөгжлийн үзүүлэлтээр, нэг бол ядуурлын индексээр харьцуулдаг болоод 20 гаруй жил болж байна. Зохиогч амьдралын чанарыг хэмжих аргачлал, болон уг аргачлалаар хийсэн судалгаанд тулгуурлан тухайн улс орнуудын нийгмийн хөгжлийг амьдралын чанарын үзүүлэлтээр харьцуулах нь чухал бөгөөд үр дүнтэй хэмээн үзсэн болно. Учир нь амьдралын чанар бол хүн, нийгмийн хөгжлийн аль алиныг нь илэрхийлдэг түгээмэл шинжтэй үзүүлэлт юм. Монгол Улсад ядуурлыг хэмжиж байгаа үндсэн хэрэгцээний босго, амьжиргааны түвшин тогтоох аргачлал, өрхийн орлогыг орлуулан тооцох аргачлал, индекслэн хэмжих үзүүлэлтүүд нь арга зүйн хувьд учир дутагдалтай, үр дүнгийн хувьд найдвартай, урт хугацаанд үнэн мадагтай биш байна.

Барууны судлаачдын хувьд амьдралын чанарыг хэмжихдээ ихэвчлэн макро түвшний хүчин зүйлсийг харгалзаж, нэг хүнд ноогдох ДНБ, ажилгүйдэл, гэмт хэрэг, байгаль цаг агаарын байдал зэрэг үзүүлэлтээр төлөөлүүлж үзсэн байна. Харин зохиогч энэхүү судалгаандаа амьдралын чанарыг хэмжих субъектив болон объектив шинж, тэдгээрийг бүрдүүлэгч элементийг аль алиныг нь тусгасан бөгөөд амьдралын чанарыг тодорхой загварт тулгуурлан урт хугацаанд судлах нь арга зүйн хувьд ач холбогдолтой болохыг энд тэмдэглэж байна.

Амьдралын чанарыг зохиогчийн санал болгож буй аргачлалын дагуу хэмжиж үзэхэд 3.48 буюу дунджаас дээгүүр коэффициенттэй, олон улсын харьцуулсан жишгээр 6.9 буюу нийт улс орнуудтай харьцуулахад объектив ба субъектив үзүүлэлтийн хэлбэлзлээс хамааран 90-98-р байранд, шилжилтийн 20 гаруй улс орнуудтай харьцуулахад эхнээсээ 8-рт тус тус байр эзэлж байна. Монгол Улс амьдралын чанарын индексэн үзүүлэлтээр бусад улс орнуудтай харьцуулахад дундаж түвшинд, амьдралын нөхцөл тааруу боловч сэтгэл ханамжийн хувьд дундаас дээгүүр түвшинд байна. Амьдрах нөхцөл улирлын онцлогоос хамаарч өвөл ба зуны харьцуулсан түвшин ялгаатай [өвөл 2.7, зун 3.4] байгааг Монгол орны эрс тэс уур амьсгалын нөхцөл байдлаар тайлбарлаж болох юм.

Эдийн засгийн тууштай өсөлт сэргэлт 2004 оноос эхэлсэн ба 2006-2008 оны хооронд Монгол Улсын эдийн засаг бүхэлдээ тэлж, өссөн нь харагдаж байна. Гэсэн хэдий ч эдийн засгийн өсөлт нь хүн амын амьдралын чанарт тодорхой бөгөөд шийдвэрлэх нөлөөтэй байсангүй. Нөгөө талаар “...эдийн засгийн хямрал нүүрлэсэн сүүлийн жилүүдэд эдийн засгийн боломжийн хот хөдөөгийн ялгаа улам бүр нэмэгдэж, хөдөөд хүмүүсийн амьдралын чанар доройтсоор байна” хэмээн үзсэн

эдийн засагчдын үнэлгээ, дүгнэлт бодит байдлаас зөрүүтэй бөгөөд зохиогчийн хийсэн амьдралын чанарын шинжилгээгээр нотлогдохгүй байна. Монголчуудын амьдралын чанарт зонхилон байгаль орчны нөхцөл, амьдралын хэрэгцээ хангагдах байдал, түүнтэй шууд уялдах хүн амын сэтгэл ханамж зонхилох нөлөө үзүүлжээ. Хөгжилтэй улс орнуудын адилаар эдийн засаг, нийгмийн хөгжил дээшилж, хэрэгцээ хангагдах тутам сэтгэл ханамж, аз жаргалын түвшин буурдаг зүй тогтол ажиглагдсангүй, сэтгэл ханамж, үнэлэмжийн түвшин улам бүр өсөн нэмэгдэх хандлагатай байна. Гэвч 2010 оноос хойшхи хугацаанд Монголчуудын амьдралын хэв маягт [амрах, эрүүл амьдрах, бясалгал, цагаан хоол гм] өөрчлөлт орж буйн зэрэгцээ уул уурхайн хөрөнгө оруулалт зогсонги байдалд орсон, мөнгөний ханш унасан, нэг хүнд оногдох өрийн хэмжээ нэмэгдсэн гэх мэтчилэн амьдралын чанарт шууд нөлөөлөх шинэ сорилтуудтай тулгарсаар байна.

Ном зүй

1. 1999*Development as Freedom*New JerseyOxford University press
2. 2012:94*Government policy; some problems of poverty reduction*UlaanbaatarManagement Academy
3. A.Sen1990*Development as Capability Expansion*NYMcmillian
4. GOM2003:41*Human development report*UlaanbaatarMunkhiin useg printing
5. M.Batbaatar2012Methodological issues of quality of life study*Sociology 2012*, #8. (377)112
6. M.Batbaatar2014"*Quality of life Mongolians*" research reportUlaanbaatarNUM
7. NSO1992-2000*Statistical yearbook*UlaanbaatarNSO
8. NSO2008*Social and Economic condition of Household*UlaanbaatarNSO
9. PSLI, Science Academy2001:141*Social reform: Changes in Lifestyle*UlaanbaatarScience Academy
10. UNDP2010*Human development report summary*UlaanbaatarUNDP
11. UNDP, NSO1998*Livelihood sampling survey*UlaanbaatarNSO
12. Worldbank, UNDP, NSO2004*Household income, Expenditure and Livelihood Survey*UlaanbaatarNSO
13. Worldbank, UNICEF, North Ireland, NSO2000*Participatory Livelihood Assessment Survey*UlaanbaatarNSO